



**АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

**Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлангийн тухай**

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.9 дэхь заалт,
“Айтүүлс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн
хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Айтүүлс” ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд
Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



А. БАТТАМИР



**АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.7 дахь заалт, “Айтүүлс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Айтүүлс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгосугай.

Ердийн гишүүд:

1. А. Баттамир
2. Б. Тамир
3. Г. Хатанболд
4. Н. Улаанхүү
5. Б. Эрдэнэжаргал

Хараат бус гишүүд:

1. Л. Тэмүүлэл
2. З. Мягмарсүрэн
3. Г. Гантуяа

ХУРЛЫН ДАРГА



А. БАТТАМИР



**АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа, гишүүдийн цалин,
урамшууллын төсвийг батлах тухай**

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.13 дахь заалт,
“Айтүүлс” ХК-ийн 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн
хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:


1. “Айтүүлс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны
болон гишүүдийн цалин урамшууллыг 43.010.000 /дөчин гурван сая арван мянган/
төгрөгөөр баталсугай.
2. Төсвийн задаргааг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



А. БАТТАМИР

Айтүүлс ХК-ийн ХЭХурлын 2020 оны
04 дугаар сарын 29-ны өдрийн хурлын
03. дугаартай тогтоолын 1-р хавсралт



**АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ**

№	Үйл ажиллагаа	Жилийн зардал, ₮
1	ТУЗ-ийн 2020 оны үйл ажиллагааны зардал	350,000₮
2	ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулал	29.160.000₮
3	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалин, урамшуулал	13.500.000₮
	НИЙТ ДҮН	43.010.000₮



АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Компанийн дүрмийг шинэчилэн батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.1 дэхь заалт, “Айтүүлс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн дүрмийн 4.1 дүгээр заалт “Компанийн зарласан хувьцаа нь нэг бүрийн үнэ 100 /нэг зуун/ төгрөгийн нэрэлсэн үнэтэй 34,452,124 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ” гэж заасныг “43 /дөчин гурван/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 34,452,124 /гучин дөрвөн сая дөрвөн зуун тавин хоёр мянга нэг зуун хорин дөрөв/ ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ” гэж өөрчилсүгэй.

2. Компанийн дүрмийн 4.2 дугаар заалт “Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 3,445,212,400 төгрөг байна” гэж заасныг “1,481,441,332 /нэг тэрбум дөрвөн зуун наян нэгэн сая дөрвөн зуун дөчин нэгэн мянга гурван зуун гучин хоёр/ төгрөг байна” гэж өөрчилсүгэй.

3. “Айтүүлс” ХК-ийн дүрмэнд дээрх өөрчлөлтийг болон бусад шаардлагатай өөрчлөлтийг оруулан, хавсралтаар баталсугай.

4. Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээг шинээр авсугай.

5. Шинэчилсэн дүрмийг улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, бусад холбогдох байгууллагад хүргүүлж баталгаажуулахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б. Ариунзул /РД: ЙС90052127/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



А. БАТТАМИР



АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Их хэмжээний хэлцэл хийх тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 88 дугаар зүйлийн 1, 2 дахь заалт, “Айтүүлс” ХК-ийн 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Айсити групп” ХК-ийн өмчлөлд буй Дархан-Уул аймаг, Дархан сум, 13-р багт байрлах 1,110,000,000 /нэг тэрбум нэг зуун арван сая/ төгрөгийн үнэлгээ бүхий үйлдвэрлэлийн зориулалттай объектийг /4300 мкв газрын хамт/, Дархан хотод модуляр дата төвийн зориулалтаар захиалан бариулж буй 930,000,000 /есөн зуун гучин сая/ төгрөгийн үнийн дүн бүхий дуусаагүй барилга /2500 мкв газрын хамт/-тай солих “Айсити групп” ХК-ийн саналыг хүлээн авч шийдвэрлэсүгэй.

1. Дээрх хэлцлийг хийх эрхийг Гүйцэтгэх захирал /Б. Тамир/-д олгосугай.

2. Компанийн тухай хуулийн 88 дугаар зүйлийн 4 дэхь заалтын дагуу дээрх хэлцлийн үр дүнг нийтэд мэдээлэхийг Төлөөлөн удирдах зөвлөл /А. Баттамир/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



А. БАТТАМИР